ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**
14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.25. № 393
танай ____________ -ны № ____________ -т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Ш.ЭНХБАТ ТАНАА

## АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагууд нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

***Санал дүгнэлтийн үндэслэл***

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 359.2 сая төгрөгийн хөрөнгө чанар, хэрэгцээ шаардлага хангаагүй, өмнөх онуудын санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй байхад 136.1 сая төгрөгийг /2012 оны 19.6 сая, 2013 оны 116.4 сая төгрөгийн нэхэмжлэхээр/ шилжүүлж эмийн зардалд тайлагнасан, 88.3 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогын 111.1 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлэхгүй зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 113.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, 130.9 сая төгрөгийн эм мэнэлэгийн хэрэгслийг бараа материалын дансанд орлого аваагүй зардалд бүртгэсэн, жилийн эцсийн тооллогоор 16.0 сая төгрөгийн бараа материал тоолоогүй, 47.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр байгаагүй, 2,842.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн, 35.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь ангилж бүртгээгүй, 26.8 сая төгрөгийн түрээсийн төлбөр аваагүй, 10.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

***Хязгаарлалттай санал дүгнэлт***

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль,УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц. ОЧИРБАТ

1110400393

## АГУУЛГА


1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## 1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2 дүгээр зүйлд заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /НАГ-АХ/2015/-СА-III-5-78/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Эрүүл мэндийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 3 дугаар сарын 05-наас 2015 оны 3 дугаар сарын 24-ны хооронд хийхээр төлөвлөн Санхүүгийн аудитын III албаны V багийн ахлах аудитор С.Гантөгс, аудитор М.Лхагвасүрэн, Т.Оюунчимэг нар 2015 оны 3 дугаар сарын 24-ны хооронд хийж гүйцэтгэв.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа эмнэлэгүүд 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2015 оны 01 дүгээр сарын 25-нд, Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 3 дугаар сарын 5-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн байна.

Нийслэлийн аудит газар аудитыг 2015 оны 3 дугаар сарын 5-наас 2015 оны 3 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 25-нд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад хүргүүлэв.

## 2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Эрүүл мэндийн тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй, түүнд нийцүүлэн гарсан зарим журам, зааварт өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 147 дугаар тогтоол, Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 75 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишигийг шинэчлэн тогтоосон байна.

## 3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1. *"эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;"*, 12.1.4. *"харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;"*, мөн тус байгууллагын дүрмэнд *"Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд эрүүл мэндийн асуудлаар Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон бусад байгууллагуудаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах, хангах чиг үүрэгтэй ажиллана."* гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 "*Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна"* гэж заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа дүүргүүдийн Эрүүл мэндийн төв, амаржих газрууд, бусад эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын тайлант хугацааны эрүүл мэндийн статистик тоон мэдээллийг товчлон дурдвал: Нийт үзлэгийн тоо 6,519.2 мянга үүнээс өвчний учир 2,006.2 мянга буюу амбулторийн үзлэг өмнөх оноос 233.9 мянгаар нэмэгдсэн, эмнэлэгт хэвтэлт 154.8 мянга байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9.7 хувиар нэмэгдэж, нийт нас баралт 3.7 хувиар буурсан, 2014 онд эхийн эндэгдэл 5, нялхсын эндэгдэл 138 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс эхийн эндэгдэл 2 тохиолдлоор, нялхсын эндэгдэл 9 тохиолдол буюу 0.56 промиллээр буурсан, нийт төрөлт 29.1 мянга буюу 4.8 хувь нэмэгдсэн байна.

Үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг авч үзвэл: Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан орны дээд хязгаар /3.2 мянга/ дотор үйл ажиллагаагаа явуулан, нийт ор хоног өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувь буюу 52.9 мянгаар нэмэгдсэн, дундаж ор хоног 2.9 хувиар буурсан, орны эргэлт 10.2 хувиар нэмэгдсэн байна.

*Эрүүл мэндийн статистик үзүүлэлт*

| д/д | Үзүүлэлт | Өмнөх | Тайлант | Өөрчлөлт өсөлт/+/, бууралт /-/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төрөлт | 27,754 | 29,099 | 1,345 | 4.8 |
| 2 | Эхийн эндэгдэл | 7 | 5 | (2) | (28.6) |
| 3 | Нялхсын эндэгдэл | 147 | 138 | (9) | (6.1) |
| 4 | Нийт нас баралт | 4135 | 3,982 | (153) | (3.7) |
| 5 | Өвчний учир амбулаторит үзүүлсэн өвчтөн | 1,772,305 | 2,006,197 | 233,892 | 13.2 |
| 6 | Үүнээс Халдварт өвчин | 7,420 | 6,975 | (445) | (6.0) |
| 7 | Эмнэлэгт хэвтсэн өвчтөн | 141,157 | 154,812 | 13,655 | 9.7 |

*Үйл ажиллагааны статистик үзүүлэлт*

| д/д | Үзүүлэлт | Өмнөх | Тайлант | Өөрчлөлт өсөлт/+/, бууралт /-/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт орны тоо | 2,703 | 2,755 | 52 | 1.9 |
| 2 | Нийт ор хоног | 897,443 | 950,351 | 52,908 | 5.6 |
| 3 | Дундаж ор хоног | 7.10 | 6.90 | (0.20) | (2.9) |
| 4 | Орны эргэлт | 52.14 | 58.08 | 5.94 | 10.23 |
|  | Нийт үзлэгийн тоо | 6,299,153 | 6,519,201 | 220,048 | 3.4 |

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны төсвийн санхүүжилтийг Эрүүл мэндийн яам болон Нийслэл, дүүргийн Төрийн сангаас олгосон байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## 4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтынсорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрүүл мэндийн яамны салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 138 тоот тушаалаар мөрдөж эхэлсэн бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн боловч стандартын өөрчлөлт, Төсвийн тухай хууль, холбогдох заавар журамд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Санхүүгийн нэгдсэн тайлан, 8 дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг 3, амаржих газар 3, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /НЭМГ/, Нийслэлийн Түргэн тусламжийн төв /НТТТ/, Энэрэл эмнэлэг, Наркологийн эмнэлэг, Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төв /ШЭНЭСТ/,Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв /НЗӨСТ/, Уламжлалт анагаах ухаан элэг судлалын төв /УАУЭСТ/, Гачуурт тосгоны хүн эмнэлэг, Жаргалант тосгоны хүн эмнэлэг, Туул тосгоны хүн эмнэлэг, Хонхор хорооны эмнэлэг, Багахангай хүн эмнэлэг нийт 26 эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа програмын үйл ажиллагаатай танилцан, асуулга явуулж түүний нарийн төвөгтэй байдлын

үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргасан байна.

## 5.Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад зарим байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

## 6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэл, дүүргийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын нэр төрлөөр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харъяа эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 67,405,386.9 мянган төгрөгөөр батлагдаж, /улсын төсвөөс 35,307,039.50 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 30,710,835.20 мянга, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 1,387,512.2 мянган төгрөг/ төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 33,809,319.50 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 30,419,995.90 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 1,551,526.91 мянга, үндсэн бус үйл ажиллагаанаас 346,147.10 мянга нийт 66,126,989.4 мянган төгрөгийн орлого, санхүүжилтийг авч батлагдсан төлөвлөгөөг 1,278,397.5 мянган төгрөг буюу 1.9 хувиар дутуу бүрдүүлжээ.

Тайлант онд үйл ажиллагааны зардалд нийт 67,405,386.9 мянган төгрөг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр нийт 66,125,882.6 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг нийт 1,279,504.3 мянган төгрөг буюу 1.9 хувиар дутуу зарцуулсан байна. Нийт зардлын 59.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд, 6.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 28.9 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал, 5.0 хувийг тэтгэмж, нэг удаагийн урамшуулалын зардалд тус тус зарцуулсан байна.

**Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын
2014 оны төсвийн орлого, зардлын судалгаа**

мянган төгрөг

| № | Үзүүлэлт | 2013 оны гүйцэтгэл | 2014 он | | 2014 оны төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан | | 2014 оны гүйцэтгэлийг 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн /илүү +, дутуу - / | Хувь | Дүн /илүү +, дутуу - / | Хувь |
| 1 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 21,045,435.9 | 30,710,835.2 | 30,419,995.9 | (290,839.3) | (0.9) | 9,374,560.0 | 44.5 |
| 2 | Улсын төсвөөс санхүүжих | 38,361,134.2 | 35,307,039.5 | 33,809,319.5 | (1,497,720.0) | (4.2) | (4,551,814.7) | (11.9) |
| 3 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,338,268.4 | 1,333,012.2 | 1,551,526.9 | 218,514.7 | 16.4 | 213,258.5 | 15.9 |
| 4 | Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 293,110.7 | 54,500.0 | 346,147.0 | 291,647.0 | 535.1 | 53,036.3 | 18.1 |
| | **Нийт санхүүжилтийн дүн** | **61,037,949.2** | **67,405,386.9** | **66,126,989.3** | **(1,278,397.6)** | **(1.9)** | **5,089,040.1** | 8.3 |
| | **Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал** | **60,974,448.4** | **67,405,386.9** | **66,125,882.7** | **(1,279,504.2)** | **(1.9)** | **5,151,434.3** | 8.4 |

## 7.<u>Шилэн дансны мэдээлэл</u>

Нийслэлийн эрүүл мэндийн газар, түүний харъяа байгууллагууд 2015 оны 1, 2 дугаар сарын төсвийн орлого, зарлагын мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулсан байна.

## 8.<u>Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:</u>

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 12 горим, 3 нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Үйл ажиллагааны бус орлогыг санхүүгийн тайланд дутуу тусгаж, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, жилийн эцсийн эргэлтийн хөрөнгийн тооллого дутуу хийсэн, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, ажиллагсдын цалинг илүү тогтоосон, нийгмийн

даатгалын шимтгэлийг дутуу тайлагнасан, нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг тайлагнаагүй, анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдэлүүд нь хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, элэгдэл дутуу тооцогдох, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомжийг зөрчих зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

## 9.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт 19,682,849.0 мянган төгрөгийн /мөнгөн хөрөнгө, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс/ ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж нийт зардлын 29.0 хувь, нийт хөрөнгийн 6.0 хувийг аудитад хамруулллаа.

## 10.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 4,232,694.5 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна.Үүнд:

1.Нийслэлийн эрүүл мэндийн газрын /НЭМГ/ харъяа байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2013 оны эхний үлдэгдэл 65,104.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. /Өргөө амаржих газрын санхүүгийн байдлын тайланд засгийн газрын сангийн эхний үлдэгдлийг 900.0 мянган төгрөгөөр илүү, Хүрээ амаржих газар 66,004.1 мянган төгрөгөөр дутуу/

<u>Шийдвэрлэсэн</u>: Дээрх алдааг Нийслэлийн эрүүл мэндийн газрын удирдлагын зүгээс зөвшөөрч санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийсэн болно.

2. НЭМГ-ын харъяа байгууллагуудын ашиглаж байгаа санхүүгийн програмын алдаанаас шалтгаалан 13 байгууллагын санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны дүн зөрүүтэй татагдсан байна.

<u>Шийдвэрлэсэн</u>:Санхүүгийн програмтай холбоотой алдааг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх арга хэмжээ

авах зөвлөмж өгснийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын удирдлагын зүгээс зөвшөөрч хариу ирүүлсэн байна.

3. Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангаас нийт 21,442.9 мянган төгрөгөөр зөрүүтэй /илүү, дутуу/ тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын холбогдох заалтыг зөрчсөн. /Наркологи эмнэлэг 6,210.0 мянга, Налайх ЭМТ 1,604.3 мянга, Өргөө амаржих 7,147.0 мянга, Хонхор хүн эмнэлэг 6,481.6 мянган төгрөг /

<u>Шийдвэрлэсэн:</u> Дээрх зөрчлийг аудитын явцад холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

4. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв 88,330.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй , Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг өөрийн эзэмшлийн байрыг хувийн хэвшлийн эмнэлэгт ашиглуулан үйл ажиллагаа явуулж байгаа боловч 26,811.9 мянган төгрөгийн түрээсийн төлбөр аваагүй, Наркологи эмнэлэг бэлэн мөнгөний гүйлгээг жижиг мөнгөн сангаар хийгээгүй, кассын машингүй, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг үндсэн үйл ажиллагааны орлого 111,113.7 мянган төгрөгийг /кассын машингүй/ бэлнээр хурааж, төрийн санд төвлөрүүлэхгүйгээр зарцуулсан зөрчил давтагдаж өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Багахангай дүүргийн Хүн эмнэлэг нэмэлт санхүүжилтийн 4,147.5 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тайлагнаагүй, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн 2,500.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлж, татварт өгөх өглөгөөр тайлагнаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.3.4, 47.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42.3, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 5-ны 65 тоот тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 1.8.1, 1.13, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн:</u> Дээрх зөрчлүүдээс аудитын явцад 4,147.5 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 2,500.0 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 226,255.6 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах зөвлөмж, албан шаардлага өгснийг НЭМГ-ын удирдлага хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн болно.

5. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 113,622.4 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.7 дах заалтыг зөрчсөн байна. /Сүхбаатар нэгдсэн эмнэлэг 82,291.9 мянган төгрөг, Багахангай хүн эмнэлэг /ажиллагсдын картын данс руу шилжүүлсэн жагсаалтгүй, цалингийн хүснэгтийг даргаар батлуулаагүй 28,324.8 мянга/ нийт 31,330.4 мянган төгрөг/

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлүүдээс 4,016.4 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 109,606.0 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгснийг байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрсөн байна. Мөн цалин хөлсний бүртгэлтэй холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлтэнд тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримт дутуу хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өгснийг НЭМГ-ын удирдлагын зүгээс хүлээн зөвшөөрч цаашид анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн байна.

6. Авлагын үлдэгдэл 7,620.8 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах болон эзэн холбогдогч тодорхойгүй авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 дэх заалтыг зөрчсөн байна. /НЭМГ 4,487.0 мянган төгрөг, Амгалан амаржих газар 3,133.8 мянган төгрөг/

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгснийг байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрсөн байна.

7. Зардлыг дансны ангилалын дагуу бүртгээгүйгээс бараа материал акталсан 43,707.8 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд буруу тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар 3.5 дах заалтыг зөрчсөн. /Налайх ЭМТ 21,055.8 мянга, Хүрээ амаржих газар 21,121.6 мянга, СХ НЭ 650.3 мянга, Энэрэл эмнэлэг 763.5 мянга, Жаргалант тосгоны эмнэлэг 116.6 мянга/

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

8. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг тайлант хугацаанд худалдан авсан нийт 130,907.6 мянган төгрөгийн эм, эмнэлэгийн хэрэгслийг бараа материалын дансанд орлого аваагүй шууд зардалд тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн дансны зааварын холбогдох заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

9. Наркологийн эмнэлэг эд хариуцагч солигдоход бараа материалын тооллогыг батлагдсан маягтаар хийгээгүй, тооцоо бодоогүй, жилийн эцсийн эргэлтийн хөрөнгийн тооллогыг дутуу хийж 16,008.6 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй байна. Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн 70.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлж, хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн зөв хийж байх зөвлөмж өгснийг НЭМГ-ын удирдлага хүлээн зөвшөөрсөн байна.

10. Хөрөнгийн үлдэгдэлд хийсэн хяналтын тооллогоор Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв 30,296.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдаж, Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 17,029.7 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгүүд биетээр байхгүй, 1 барилгыг /складын зориулалтаар ашиглаж байгаа/ данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2 дах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг байгууллагуудын удирдлагад хүргүүлж, тооллогоор дутагдсан хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авах бүртгэлгүй хөрөнгийг бүртгэх арга хэмжээ авах зөвлөмж өгснийг НЭМГ-ын удирдлага хүлээн зөвшөөрсөн байна.

11. Уламжлалт анагаах ухаан, элэг судлалын төв нь өмнөх оны завсрын аудитаар Богд-Уул сувилалын газрын нийт 2,833,050.0 мянган төгрөгийн барилгыг давхардуулан бүртгэсэн зөрчлийг залруулах албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв 9,563.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулж бүртгэсэн, Багануур дүүргийн эрүүл мэндийн төв барилга байгууламжид 4 өөр нэр төрлийн нийт 35,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нэгтгэж бүртгэсэн, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар нийлүүлсэн нийт 395,047.9 мянган төгрөгийн хөрөнгө, /Туул тосгоны эмнэлэг 22,878.3 мянга, Багахангай хүн эмнэлэг 99,369.6 мянга, Багануур Эрүүл мэндийн төв 254,100.0 мянга, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв 18,700.0 мянга/, өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан барьсан автомашины 2 гражийг данс бүртгэлд тусгаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2, УСНББОУС-ын 17.18 дах заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлүүдээс 395,047.9 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 2,877,813.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрсөн байна.

12. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг санхүүгийн тайлангаар дансны өглөгийн үлдэгдэлгүй байхад 2012-2013 оны нэхэмжлэхээр нийт 136,073.5 мянган төгрөгийг /2012 оны 8 нэхэмжлэхээр 19,614.1 мянга, 2013 оны 32

нэхэмжлэхээр 116,459.4 мянга/ шилжүүлж эмийн зардалд тайлагнасан, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв 10,920.7 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2, 7.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн:</u> Дээрх зөрчлүүдээс 10,920.7 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 136,073.5 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

13. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв зарим ажиллагсдын цалинг Засгийн газраас тогтоосон жишиг цалингаас дээгүүр /1-29 хувь илүү/ тогтоож нийт 78,178.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.3, Засгийн Газрын 2014 оны "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 147 дугаар тогтоол, Засгийн Газрын 2012 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 78, 2014 оны 75 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна

<u>Шийдвэрлэсэн:</u> Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлж, цалин хөлсийг Засгийн газрын тогтоосон жишиг болон батлагдсан төсөвт багтаан үнэн зөв тооцож олгох зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

14. Эрүүл мэндийн салбарын зарим албан тушаалын үндсэн цалинг нэмэгдүүлэх эрх олгох тухай Эрүүл мэндийн сайдын 2010 оны 123 тоот тушаалын 2 дах заалтыг зөрчиж нийт 45,312.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс тооцож олгожээ. /Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв 18,944.8 мянга, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв 17,192.7 мянга, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв 9,175.0 мянган төгрөг/

<u>Шийдвэрлэсэн:</u> Зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг байгууллагуудын удирдлагад хүргүүллээ. Ажиллагсдад олгох цалин хөлсийг холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн зөв тооцож байх зөвлөмж өгснийг НЭМГ-ын удирдлагын зүгээс хүлээн зөвшөөрч цаашид анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн байна.

15. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг нийгмийн даатгалын тайланд ажиллагсдын цалинг дутуу тайлагнаж 10,705.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1 дэх заалтыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн:</u> Зөрчлийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн нийт 359,161.9 мянган төгрөгийн хөрөнгө чанарын болон хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. /Хүрээ амаржих газар 79,800.0 мянга, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв 49,308.2 мянган төгрөг, Амгалан амаржих газар 230,053.7 мянган төгрөг/

   Шийдвэрлэсэн: Хөрөнгө оруулалтыг хийхдээ үр өгөөж, хэрэгцээ шаардлагыг тооцож, судалж ажиллах зөвлөмж өгснийг Эрүүл мэндийн яаманд асуудлыг тавьж, хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн байна.

2. Амгалан амаржих газар ахмадууддаа хүндэтгэл үзүүлээгүй Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

   Шийдвэрлэсэн: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн байна.

3. Эрүүл мэндийн төвүүдийн бүтэц, орон тооны жишиг шинэчлэгдээгүй, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэгүүдийн ажиллагсдын орон тоог албан тушаалаар нарийвчилж батлуулаагүйгээс цалингийн зардалд зориулалтын бус зардлыг тайлагнах, нэмэгдлүүдийг илүү олгох, орон тоо хэтрүүлэх зэрэг зөрчил гарч, ямар орон тоо илүү, дутуу ажиллаж байгаад хяналт тавих боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрмийн 2.7, 4.1.1 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

   Шийдвэрлэсэн: Төсвийг зохистой удирдах нөхцлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц орон тоог нарийвчилж, үндэслэлтэй батлах арга хэмжээ авах зөвлөмж өгөв. НЭМГ-ын зүгээс зөвшөөрч цаашид анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн байна.

4. Наркологи эмнэлэг цалингийн тооцооны хүснэгтээс 393.9 мянган төгрөгийг илүү шилжүүлж, цалингийн зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

   Шийдвэрлэсэн: Зөрчлийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5. Эрүүл мэндийн зарим байгууллагууд 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар татварын байгууллагад нийт 110,714.5 мянга, нийгмийн даатгалын байгууллагад нийт 15,692.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь татвар болон нийгмийн даатгалын

шимтгэлийн өглөгийг хуулийн хугацаанд нь төлөөгүйгээс цаашид алданги, торгуульд орж төсөв хүндрэх эрсдэлд орох магадлалтай байна.

## 11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс гарсан 4,075,825.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй байна.

## 12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар нийлүүлсэн хөрөнгүүдийг бүртгэлд тусгаагүй, зарим хөрөнгө чанарын болон хэрэгцээ шаардлага хангахгүй, зарим байгууллагууд 2013 оны завсрын аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй, холбогдох зарим хууль, заавар, журмыг хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал давтагдан гарч байна.

## 13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас эм, хоолны зарцуулалт болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд аудитыг бүрэн хэмжээгээр хийгээгүй, Нийгмийн даатгалын ерөнхий газрын харъяа Эрүүл мэндийн даатгалын газраас эмнэлэгүүдэд олгосон санхүүжилтийн дэлгэрэнгүй судалгааг ирүүлээгүй тул эрүүл мэндийн санхүүжилтийг тулган баталгаажуулаагүй зэрэг асуудлыг завсрын аудитаар үзэх болно.

## 14.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4,592,250.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 540,370.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 17,615.3 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулахаар төлбөрийн акт тогтоож, 394,361.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч 3,639,902.2 мянган төгрөгийн зөрчилд дахин давтан гаргахгүй байхаар албан шаардлага өглөө.

**15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Нийслэлийн аудитын газраас аудит хийж нийт 14 зөвлөмж өгснөөс 9 зөвлөмжийг хэрэгжүүлж, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

**16. Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 15 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

ДЭД ДАРГА Т.САРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

САНХҮҮГИЙН АУДИТЫН
Ү БАГИЙН АХЛАХ АУДИТОР С.ГАНТӨГС

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР Т.ОЮУНЧИМЭГ
М.ЛХАГВАСҮРЭН

2015 оны 3 дугаар сарын 25

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## Менежментийн захидал

**<u>Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:</u>**

Асуудал 1
Санхүүгийн тайлан нэгтгэлийн талаар ....................................................21

Асуудал 2
Санхүүгийн тайлагнал ..................................... 21

Асуудал 3
Орлогын бүртгэл ....................................22-23

Асуудал 4
Мөнгөн хөрөнгө ...................................................23-24

Асуудал 5
Авлага .....................................................................25

Асуудал 6
Бараа материал :...................................................26

Асуудал 7
Үндсэн хөрөнгө .....................................................27-28

Асуудал 8
Өр төлбөр .......................................................... 29

Асуудал 9
Цалин хөлс .......................................................... 30-32

Асуудал 10
Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоолол .......................................33

**<u>Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:</u>**

Асуудал 1
Хөрөнгө оруулалт .................................................34
Асуудал 2
Бусад хууль, заавар
Журмын хэрэгжилт .......................................34-35

2015 оны 03 дугаар сар

## Менежментийн захидал

Нийслэлийн Аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон харъяа эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал1: Санхүүгийн тайлангийн нэгтгэл**

**НАГ-ын ажиглалт:**

- Нийслэлийн эрүүл мэндийн газрын /НЭМГ/ харъяа байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2013 оны эхний үлдэгдэл 65,104.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. /Өргөө амаржих газрын санхүүгийн байдлын тайланд засгийн газрын сангийн эхний үлдэгдлийг 900.0 мянган төгрөгөөр илүү, Хүрээ амаржих газар 66,004.1 мянган төгрөгөөр дутуу/
- НЭМГ-ын харъяа байгууллагуудын ашиглаж байгаа санхүүгийн програмын алдаанаас шалтгаалан 13 байгууллагын санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны дүн зөрүүтэй татагдсан байна.

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

- НЭМГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг нэгтгэж байх.
- Аудитаар илэрсэн алдааг тухайн тайлант жилд залруулж, нэгдсэн тайланд зөв тусгаж байх;
- Санхүүгийн програмтай холбоотой алдааг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

**Эрсдэлүүд**:

- Санхүүгийн тайланг нэгтгэхдээ бүрэн, үнэн зөв тусгаагүй байх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Зөрчил дутагдлыг НЭМГ-ын удирдлага хүлээн зөвшөөрч цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар менежментийн захидалд хариу ирүүлсэн байна.

**Асуудал 2: Санхүүгийн тайлагнал**

**НАГ-ын ажиглалт:**

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангаас нийт 21,442.9 мянган төгрөгөөр зөрүүтэй /илүү, дутуу/ тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааварын холбогдох заалтыг

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

- Санхүүгийн тайланг холбогдох заавар журмын дагуу үнэн зөв тайлагнах;

зөрчсөн. /Наркологи эмнэлэг 6,210.0 мянга, Налайх ЭМТ 1,604.3 мянга, Өргөө амаржих 7,147.0 мянга, Хонхор хүн эмнэлэг 6,481.6 мянган төгрөг/

**Эрсдэлүүд**:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Зөрчил дутагдлыг НЭМГ-ын удирдлага хүлээн зөвшөөрч цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар менежментийн захидалд хариу ирүүлсэн байна.

**Асуудал 3: Орлогын бүртгэл**

**НАГ-ын ажиглалт:**

- Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв 88,330.0 мянган төгрөгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний орлогыг бэлнээр хурааж, төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан, санхүүгийн тайланд тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.3.4. *"төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх ... 35.2. "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.*" заалтыг зөрчсөн байна.
- Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг өөрийн эзэмшлийн байрыг хувийн хэвшил эмнэлэгт ашиглуулан үйл ажиллагаа явуулж байгаа боловч 26,811.9 мянган төгрөгийн түрээсийн төлбөр аваагүй нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 5-ны 65 тоот тогтоолоор баталсан "Нийслэлийн

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

- Орлогыг санхүүгийн тайланд бүрэн үнэн зөв тайлагнах;
- Өөрийн эзэмшлийн байрыг бусдад түрээслэхдээ холбогдох хууль, заавар журмыг хэрэгжүүлж, түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх;

өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 1.8.1. *"Нийслэлийн төсөвт байгууллага нь бусад нийслэлийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй эд хөрөнгийг өмч ашиглалтын гэрээгээр;"*, 1.13. *"Нийслэлийн өмчит хуулийн этгээд нь өөрийн санхүүгийн тайланд бүртгэлтэй, эзэмшиж буй барилга байгууламжийн доторх илүүдэлтэй талбайг түрээслэхдээ талбайн түрээсийн орлогын 60 хувийг Өмчийн харилцааны газарт төвлөрүүлнэ."* заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**:

- Орлого дутуу тайлагнах;
- Түрээсийн орлогыг аваагүй байх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 4: Мөнгөн хөрөнгө**

**НАГ-ын ажиглалт:**

- Наркологи эмнэлэг бэлэн мөнгөний гүйлгээг жижиг мөнгөн сангаар хийгээгүй, кассын машингүй, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг үндсэн үйл ажиллагааны орлого 111,113.7 мянган төгрөгийг /кассын машингүй/ бэлнээр хураах, төрийн санд төвлөрүүлэхгүйгээр зарцуулсан зөрчил давтагдаж өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35.2.*"Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна."*, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

- Үйл ажиллагааны орлогыг кассын машингүй хурааж, төрийн сангийн дансанд төвлөрүүлэхгүй зарцуулдаг, анхан шатны баримтыг дутуу бүрдүүлдэг зэрэг зөрчлийг таслан зогсоох
- Нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг санхүүгийн тайланд тусгах
- Тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу тухай бүрд татварын дансанд шилжүүлж байх

журам"-ын 2.6. "*Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана."* заалтыг зөрчсөн байна.

- Багахангай дүүргийн Хүн эмнэлэг нэмэлт санхүүжилтийн дансны 4,147.5 мянган төгрөгийн гүйлгээг /эрүүл мэндийн довтолгоо арга хэмжээний санхүүжилт 3,697.9 мянга, өмнөх оны төсвийн урамшуулал 449.6 мянга/ санхүүгийн тайланд тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 47.2.*"Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна."* заалтыг зөрчсөн байна.
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 81,281.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.7. *"анхан шатны баримт бүрдүүлээгүй, ... байх;"* заалтыг зөрчсөн байна. /Сүхбаатар нэгдсэн эмнэлэг 78,275.5 мянга, Багахангай хүн эмнэлэг 3,005.6 мянган төгрөг/
- Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн 2,500.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлж, татварт өгөх өглөгөөр тайлагнаагүй нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42.3.*"Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна."* заалтыг зөрчсөн.

**Эрсдэлүүд**:

- Баримтыг бүрдүүлэлгүй орлого, зарлагаар хүлээн зөвшөөрсөн байх;
- Санхүүгийн тайланд мөнгөн гүйлгээг тусгахгүй байх;
- Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлэхгүй байх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 5: Авлага**

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**<u>НАГ-ын ажиглалт:</u>**

- Авлагын үлдэгдэл 7,620.8 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах болон эзэн холбогдогчгүй авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. *"…. бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах;"* заалтыг зөрчсөн байна. /НЭМГ 4,487.0 мянга, Амгалан амаржих газар 3,133.8 мянган төгрөг/

**<u>НАГ-ын зөвлөмж:</u>**

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, барагдуулах арга хэмжээ авах;
- Эзэн холбогдогч тодорхойгүй авлагын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

**Эрсдэлүүд**:

- Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байх;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 6: Бараа материал**

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ-ын ажиглалт:**

- Зардлыг дансны ангилалын дагуу бүртгээгүйгээс бараа материал акталсан 43,707.8 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд буруу тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар 3.5 "*Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ"* заалтыг зөрчсөн. /Налайх Эрүүл мэндийн төв 21,055.8 мянга, Хүрээ амаржих газар 21,121.6 мянга, Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэг 650.3 мянга, Энэрэл эмнэлэг 763.5 мянга, Жаргалант тосгоны эмнэлэг 116.6 мянга/
- Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг тайлант хугацаанд худалдан авсан нийт 130,907.6 мянган төгрөгийн эм эмнэлэгийн хэрэгслийг бараа материалын дансанд орлого аваагүй зардалд шууд тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн дансны зааварын холбогдох заалтыг зөрчсөн байна.

- Наркологийн эмнэлэг эд хариуцагч солигдоход бараа материалын тооллогыг батлагдсан маягтаар хийгээгүй, тооцоо бодоогүй, жилийн эцсийн эргэлтийн хөрөнгийн тооллогыг дутуу хийж, 16,008.6 мянган төгрөгийн бараа материал тоолоогүй байна. Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн *2/ "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;"* Нягтлан бодох бүртгэлийн тухай *хуулийн "11.2. Эд хөрөнгийн тооллогыг дараахь тохиолдолд заавал хийнэ: 11.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой*

**НАГ -ын зөвлөмж:**

- Зардлын ангилал болон дансны бичилтийг Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу үнэн зөв бүртгэх;

- Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн зөв хийх;

*холбоотой ажилтан солигдох үед;"* заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**:

- Хөрөнгийн тооллогоор хөрөнгө дутагдах;
- Тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй;
- Данс бүртгэлд байгаа хөрөнгө өөрийн эзэмшилд биетээр байхгүй байх;

**Төсвийн захирагчийн хариу**

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 7: Үндсэн хөрөнгө**

**НАГ-ын ажиглалт:**

- Хөрөнгийн үлдэгдэлд хийсэн хяналтын тооллогоор Сонгинохайрхан эрүүл мэндийн төв 30,296.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдаж, Сүхбаатар нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй /3,480 га зүлэгжүүлсэн талбай, 16 бут сөөг, 113 навчит мод, авто зам, сүүдрэвч, зүлэгжүүлсэн талбай ... гм/ нийт 17,029.7 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгүүд биетээр байхгүй, 1 барилгыг /складын зориулалтаар ашиглаж байгаа/ данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. *"санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;"* заалтыг зөрчсөн байна.
- Уламжлалт анагаах ухаан, элэг судлалын клиник төв нь өмнөх оны аудитаар Богд-Уул сувилалын газрын нийт 2,833,050.0 мянган төгрөгийн барилгыг давхардуулан бүртгэсэн зөрчилд залруулах албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй;
- Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн нэгдэл 9,563.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

**Тэргүүлэх ач холбогдол 1:**

**НАГ -ын зөвлөмж:**

- Хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь үнэн зөв хийж тооллогоор дутагдсан хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн хөрөнгийг холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж данс бүртгэлд тусгах;
- Хандив тусламжаар ирсэн хөрөнгийг үнэлгээний байгууллагаар үнэлүүлэн данс бүртгэлдээ тусгах;
- Үндсэн хөрөнгийн дансанд давхардуулан бүртгэсэн болон бүртгэлгүй хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах;

4.1.2. *"санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;"* заалтыг зөрчсөн;

- Багануур дүүргийн эрүүл мэндийн төв барилга байгууламжид 4 өөр нэр төрлийн нийт 35,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нэгтгэн бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1."*Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." УСНББОУС-ын* 17.18. *"Тодорхой тохиолдолд хөрөнгийн нийт зарлагыг түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хувиарлаж, хэсэг тус бүрийг тус тусад нь бүртгэх нь тохиромжтой"* заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

